


Хүн бол амьд сэтгэл

Хүн анх Ертөнцийн Эзэнээр бүтээгдсэн нь итгэгчдийн дунд маргаангүй. Гэвч хүний бүтэцийн талаар философичид болон теологичид олон зууны турш маргаж ирсэн. Нэг хэсэг нь хүнийг материаллаг, материаллаг бус хоёр хэсгээс бүрддэг гэж үздэг бол нөгөө хэсэг нь “үгүй, хүн гурван хэсгээс буюу махбод, сэтгэл (англи: soul), амин сүнс (англи: spirit) гурваас бүрддэг” гэж үздэг.

Уг нь Их Эзэн Адамыг бүтээсэн түүхэнд энэ маргааны тайллыг тов тодорхой өгүүлсэн байдаг. Үүнд:

“Бурхан ИАВЭ хөрс шороогоор хүмүүнийг урлаад, амин амьсгалыг хамраар нь үлээхэд хүн амьд бодгаль болжээ” (Эхлэл 2:7, СМО).



Энэ ишлэлийн дагуу хүний махбод энэ дэлхийн хөрс шороогоор бүтээгдсэн (мөн 1 Коринт 15:47-г үзнэ үү). Тиймээс бид өнөөдөр ч махбодоо хөрс шорооны бүтээгдэхүүнээр тэжээдэг (үүнд өвс иддэг малын мах ч гэсэн орох нь тодорхой).



Энэ ишлэлээс харахад хүний махбод их чухал. Амь ороогүй биеийг нь “махбод” гэж нэрлээгүй, харин шууд “хүн” гэсэн. Бие нь тэр хүн өөрөө. Тиймээс нас барсан Есүсийг шинэ хадан булшинд оршуулсан тухай ишлэл дээр Түүний “шарилын” тухай яриагүй, харин “Есүсийг [буюу Өөрийг нь] тэнд тавьжээ” гэсэн (Иохан 19:40-42).

Харин амь нь Бүтээгч Эзэнээс ирсэн. Амьсгалаа бид өнөөдөр ч тэнгэрийн агаараас авна. Амин амьсгалыг Бүтээгч Эзэн хүний хамраар үлээж оруулсан. Хүний биед салхи мэт орсон амийн хүчийг Библид мөн “сүнс” гэдэг.¹

“Сүнсгүй бие үхмэл” билээ (Иаков 2:26; мөн Дуулал 104:30-г үзнэ үү). Тийм ч учраас “амин сүнс” гэсэн монгол хэллэг учиртай. “Сүнс” гэдэг нь “амь” гэсэн утгатай учраас тэр юм. Хүний амь Бүтээгч Эзэнээс гаралтай болохоор “хүн зөвхөн талхаар бус, харин Бурханы амнаас гарах үг бүрээр амьдарна” (Матай 4:4). Есүсийн бидэнд “хэлсэн үгс бол сүнс ба амь билээ” (Иохан 6:63).

Дээрх ишлэлийг арай өөр орчуулгаар дахин уншъя: “Бурхан ИАВЭ хөрс шороогоор хүмүүнийг урлаад, амин амьсгалыг хамраар нь үлээхэд хүн **амьд сэтгэл** болжээ” (Эхлэл 2:7; АБ2019: “амьд бодгаль”, АБ2013: “амьд биет”, АБ2004: “амьд оршигч”).²

1 Еврей ба грек хэлний аль алинд “сүнс” ба “салхи” нэг л үг. Еврей “рү-ах” гэдэг нь “сүнс” мөн “салхи” гэсэн утгатай. Грек “пнеума” мөн адил “сүнс”, “салхи” хоёрыг хэлнэ. “Пнеу-ма” (салхи, сүнс) гэдэг нь “үлээсний үр дүн” гэсэн үндсэн утгатай үг. Хүний сүнс Их Эзэний үлээсний үр дүнд бий болсныг бид «Эхлэл» номоос мэднэ.



Хүний махбод, амин сүнс нэгдсэн байх үед хүн “амьд сэтгэл” юм. Сэтгэл бол махбод, сүнс хоёр нийлсний үр дүн. Сэтгэл гэгч зүйл хүнд байхгүй, хүн “сэтгэл бүхий амьтан” биш, Библийн дагуу хүн өөрөө сэтгэл билээ.³ Амийн амьсгал ороход хүнд ухаан сэхээ нь орж юмыг харж, сонсож, мэдэрч, үнэрлэж чаддаг болсон. Энэхүү үр нөлөөг Библид “сэтгэл” гэж нэрлэдэг. Сэтгэл бол махбодод орсон амийн хүчийн илрэл юм.

Бичвэрийн дагуу “махбодын сэтгэл нь цусандаа байдаг” (Левит 17:11; АБ: “амь” гэсэн нь буруу!). Гар юмуу хөл боогдохоор цус нь гүйхээ больж тэр хэсэг мэдээгүй болдог. Толгой тархи луу урсах цусны хэмжээ огцом багасгахад хүн ухаан алддаг. “Сэтгэл” буюу “ухаан сэхээтэй байх” нь цустай шууд холбоотой учраас тэр. Сэтгэлийг мэдээ, мэдрэлтэй байхын тээгч гэж тодорхойлж болно.

Улмаар, цус хөрст дэлхийгээс авсан тэжээл, агаараас авсан хүчил төрөгчийг махбодод байнга тарааж амийг нь тэтгэдэг.

2 Энд “бодгаль” гэж орчуулсан үг еврейгээр “нэфэш” бөгөөд “нэфэш”-ийг олон тохиолдолд “сэтгэл” гэж орчуулдаг. Гэвч монголоор “амьд сэтгэл” гэж ярьдаггүй нь тэр юмуу АБ, СМО энд “сэтгэл” гэж орчуулаагүй. Үүнээс гадна, олон тохиолдолд “сэтгэл”, “амь” хоёрыг хольж хутгахаар “нэфэш” Их Эзэний хэлсний дагуу яг юу болохыг барьж авахад хэцүү болгодог. Бид ер нь тус еврей үгийг хаана ч “сэтгэл” гэж орчуулахаар шийдсэн. Тэгэхээр хүн “амьд сэтгэл” болжээ. Хүн бол амьд сэтгэл юм.

3 Үүний нэгэн жишээ 1 Петр 3:20-с олдоно. Петр Ноахын онгоцонд “найман сэтгэл орж, усаар дамжин аврагджээ” гэж бичдэг. АБ-д энд “найман хүн” гэж орчуулсан ч грек эхэнд “найман сэтгэл” гэж бичсэн байна. Хүн сэтгэл мөн учраас АБ-ын орчуулгыг нарийн үгчлэн орчуулаагүй ч гэсэн, утгаараа зөв хэмээн дүгнэж болно.



Энэ утгаар ч гэсэн ухамсарт сэтгэл нь махбод, сүнс хоёрын нэгдэл юм.

Махбодын цусны эргэлтийн системийн төв нь цээжинд цохилох зүрх юм. Сэтгэлийн төвийг Библид мөн адил “зүрх” гэдэг. Монголоор “зүрх сэтгэл” гэдэг нь учиртай. Зүрх сэтгэл бол хүний сэдэл эрмэлзлэл үүсэх, шийдвэр гаргах бодол санааны төв юм (Еврей 4:12).



Бие махбод, амин сүнс, сэтгэл гурвыг зурагтаар дүрсэлж болно. Махбод нь телевизорын аппарат мэт, амин сүнс бол эрчим хүч өгдөг цахилгаан мэт. Тогийг зурагтад залгахаар дэлгэцэнд “мэдээ ордог”. Тэр бол “сэтгэл” мэт.

Эсвэл зулыг авч үзье. Зулын гол хүний махбодыг төлөөлвөл ууж байгаа тос нь хүний иддэг хоол тэжээл. Зулыг асахын тулд гаднаас тодорхой хэмжээний эрчим хүч авах ёстой.

Тэр эрчим хүч бол амин сүнс. Зулын гол амьд дөл авсан цагаас эхлэн шатахуунаа агаарын хүчил төрөгчтэй хольж үүнээс гарах эрчим хүчээр өөрөө гэрэл, дулааныг гаргадаг. Гэрэл, дулаан нь сэтгэлийг дүрсэлнэ. Хэзээ нэгэн цагт аль нэг хүчин зүйл тасрахад зулын дөл унтардаг. Гэрэл, дулаан нь хаашаа бүү мэд алга болдог.

Одоогийн бие махбод маань Библийн хэллэгээр “сэтгэлэг”⁴ чанартай (1 Коринт 15:44; англиар “soulish”).

4 АБ: “төрөлх бие” гэтэл грек: “сума психикос” – психологи буюу сэтгэлзүйтэй харьцуулна уу



Бие маань сэтгэлээс бүрэн хамааралтай буюу мэдрэмжээр удирдуулдаг гэсэн үг. Өөрөөр хэлбэл, сэтгэлийн шаардлагыг хангахгүй бол болохгүй. Энэ бол хүнийг “сэтгэл” гэж нэрлэх бас нэгэн шалтгаан.⁵



“Сэтгэлэг бие” маань тав тухтай байдлыг эрэлхийлж, сэтгэл хангалуун байхыг эрхэмлэн, таван мэдрэхүүд таатай зүйлсийн хойноос явна. Харин сүнслэг зүйлд татагддаггүй. Амин сүнс буюу амьдрах хүч маань дотор орших үхлийн хүчээр дарагдсан учраас тэр. Үүний үр дагавар нь хүн сул дорой бөгөөд ертөнцийн мөнх бусыг үзүүлдэг явдал.

Хүний бүтэц үхлийг ч ойлгомжтой болгодог

Хүн анх хэрхэн бүтээснийг ойлговол үхэл нь чухам юу болох нь ойлгомжтой. Библийн дагуу үхэл гэдэг нь амьгүй байдалд “буцах буцалт” мөн. Ертөнцийн Эзэн Адамд хэлэхдээ (Эхлэл 3:19):

“Чи газар шороондоо буцталаа духныхаа хөлсийг дуслуулан байж хоолоо олж иднэ...”

5 Итгэгч хүн “сэтгэлэг биетэй” боловч Ариун Сүнс бие нь дотор оршин суудаг болсон. Тиймээс итгэгч Есүс шиг “сэтгэлэг хүн” биш сүнсээр удирдуулсан “сүнслэг хүн” байхаар дуудагдсан. “Бурханы бидэнд бэлэглэсэн юмсыг мэдэхийн тулд бид ертөнцийн сүнсийг бус, харин Бурахын Сүнсийг хүлээн авсан юм... Сэтгэлэг [грек: психикос] хүн Бурханы Сүнсний зүйлсийг хүлээж авдаггүй. Ийм хүнд эдгээр нь мунхаглал бөгөөд сүнслэгээр тунгаан цэгнэх учиртай зүйлсийг тэр мэдэж чадахгүй.” (1 Коринт 2:12-16).



Хүн нас барахад махбод нь газар шороонд буцдаг. Үүнийг бид бүгд амьдралаас мэднэ. Гэтэл нас барсан шалтгааныг нь мөн мэдэх үү? Мөнхийн Эзэн амь амьсгалыг нь татаж авсан учраас хүн үхдэг билээ.

Үүнд:

*“Хэрэв Тэрбээр... хүмүүнд өгсөн сүнс ба амьсгалаа
Өөртөө буцааж хураавал
Махбодтон бүр хамтдаа мөхөх байсан
Хүн төрөлхтөн шороондоо буцах байсан”* (Иов 34:14-15).

Мөн:

*“Таныг нүүр буруулахад тэд хямардаг.
Та амьсгалыг нь татахад тэд үхээд
Тоос шороондоо буцаж очдог.”* (Дуулал 104:29)

Хүний үхэл Ертөнцийн Эзэний тогтоосон цагт тохиолно. Монголчууд “амь хураах”, “амьсгаа хураах” тухай ярьдаг нь зөв. Гэтэл энэ нь давхар утгатай. Бүтээгч Эзэн хүний амьсгааг татан авч хураадаг учраас хүн амьсгал тасран амь хураана. Ингээд бие махбод, амин сүнс хоёр үхлийн үеэр бие биенээсээ салдаг. Махбод нь хөрс шороонд буцна, харин амин сүнс нь “үүнийг өгсөн Бурхандаа буцна” (Номлогчийн үгс 12:7).



Паул үүнийг сайн ойлгоод үхлийг танил грек үг болох “анализ” буюу “задаргаа” гэсэн үгээр илэрхийлдэг. Тэрээр Тимотод “явах [=нас барах] цаг минь болжээ” гэж бичихдээ грекээр “миний задран тарах цаг боллоо” гэсэн (2 Тимот 4:6).



Хүнийг бүрэлдүүлдэг хоёр хэсэг анх хаанаас ирсэн тийшийгээ эргэж буцахын тулд бие биенээсээ салж задран тарах учраас тэр.

Гэтэл амин сүнс Бүтээгч Эзэндээ буцахдаа юм мэдэрдэггүй, өөрийн оршин байгаагаа мэдэхгүй. Амин сүнс хүний мэдээ, мэдрэлийн төв биш гэдгийг санаарай. Тэр чадварууд амин сүнс бие махбодтой нэгдсэн байх зөвхөн тэр үед, өөрөөр хэлбэл амьд сэтгэл байх үедээ хүнд бий. Монголчууд нас барахыг “сүнсээ үдэх” гэж хэлдэг нь энэ ойлголтыг харуулна.

Хүний ухамсарт сэтгэл үхэхлээр яах вэ?

Олон хүний ойлголтоор сэтгэл үхлээс болж бие махбодоосоо “чөлөөлөгдөн” аль нэг тийш хальж одно. Нэг бол тэнгэр, нэг бол там явна.

Эсвэл шинэхэн бие махбодод орж, хойд төрөлдөө төрнө. Сэтгэл нь бие махбод, амин сүнс хоёр нийлсний үр дүн болохыг нэгэнт ойлгосон бол сэтгэл дангаараа хальж одох тухай дээрх төсөөлөл бүгд буруу болох нь ойлгомжтой.

Янз бүрийн шашинд “үхэшгүй мөнх сэтгэл”-ийн тухай



онол сургаал бий. Энэ сургаал харин “Та нар үхэхгүй ээ!” гэсэн могойн хэлсэн анхны худлаас гаралтай (Эхлэл 3:4).



Үхэл гэдэг нь үл орших байдалд эргэж буцахыг хэлдэг гэж ойлгосон бол ухамсарт сэтгэл мөн адил үл орших байдалд буцах ёстойг ч ойлгоно. Хүн бий болохоосөө өмнө сэтгэл, ухамсар нь хаана байсан билээ?

Хаана ч байгаагүй, оршин тогтнодоггүй байсан. Махбод, амин сүнс нэгдэхээр л сэтгэл нь бий болсон, өөрөөр хэлбэл сэхээ орсон билээ. Тэгвэл бие махбод, амин сүнс хоёр салахад ухамсарт сэтгэл нь эргээд үгүй болно. Өөрөөр хэлбэл, сэхээ үгүй болно.

Та төрөхөөсөө өмнө юу ч мэдээгүй, юу ч мэдрээгүй байсан шигээ нас барсныхаа дараа ч юу ч мэдэхгүй, юу ч мэдрэхгүй байх болно. Монгол толь бичгийн дагуу “сэтгэхээ зогсох” гэдэг нь “үхэх” гэсэн утгатай бөгөөд үхлийн энэ талыг илэрхийлэхэд оновчтой үг.

Үүнийг Библид “гүн нойрсох” гэсэн дүрслэлээр илэрхийлнэ. Библид үхэгсдийг “нойрсогсод” гэж нэрлэдэг нь тийм учиртай (жишээ нь, 1 Коринт 15:6; 1 Тесалоник 4:14). Монголчууд ч гэсэн талийгаачдыг “үүрд тайван нойрс доо” гэж үддэг учраас Библийн энэ хэллэг шууд ойлгогдоно. Анир чимээгүй, гүн харанхуй “Үхэгсдийн орон”-ы шороонд үхэгсэд нойрсдог. Энэ “унтах орон” бол материаллаг махбодын орох материаллаг булшийг хэлдэг. Харин хийсвэр сэтгэлийн хувьд “Үхэгсдийн орон” бол үл мэдэх, үл үзэгдэх байдлыг нэрлэсэн нэр.⁶

6 Еврей “Шеол” (буюу Үхэгсдийн орон) гэсэн нэр “ша-ал” буюу “асуух” гэсэн үйл үгнээс гаралтай. Иймд Үхэгсдийн оронг асуултын тэмдэг маягаар ойлгож болно. Грек “Хадес” (мөн Үхэгсдийн орон) шууд орчуулахад “үл үзэгдэх” гэсэн утгатай.



Дээр хүнийг зурагттай зүйрлэсэн билээ. Хүн нас барах нь зурагтыг тогноос салгахтай адил. Тогийг салахад дэлгэцэнд гарч байсан зүйлс гэнэт үзэгдэж, сонсогдохоо больдог.


Хаашаа алга болсныг хэн ч хэлж чадахгүй. Сэтгэл “Үхэгсдийн орон”-д орсон нь тийм учиртай.

Их Эзэний бидэнд өгсөн агуу их найдлага

Хүн төрөлхтөн хэзээд үхлээс “үхтлээ” айдаг. Өөрөө үгүй болно гэдэг нь аймшигтай төсөөлөл шүү дээ. Харин Есүс биднийг үхлээс аврахаар ирсэн. Тэрээр “үхлийн хүчийг баригч буюу диаволыг үхлээрээ хүчингүй болгоод бүх насаараа үхлийн айдаст боолчлогдож байсан бүгдийг чөлөөлөх юм” (Еврей 2:14-15).

Тийм ч учраас: *“Бодол санаа минь баясаж, хүсэл сэтгэл минь хөөрнө. Бие махбод минь ч амар жимэр аж төрнө. Учир нь Та намайг [еврей: сэтгэлийг минь] Үхэгсдийн оронд орхихгүй...”* (Дуулал 16:9-10)

Энэ үг эхний ээлжинд Есүсийн тухай мөн (Үйлс 2:27-32). Тэгээд энэ үгийг бичсэн Давид хааны тухай. Гэхдээ мөн адил та бидний тухай ч зөгнөсөн зөгнөл. Бүтээгч Эзэн маань биднийг ч гэсэн Үхэгсдийн оронд орхихгүй! Түүний бидэнд өгсөн агуу их итгэл найдвар бол “дахин амилалт” юм.





Сонирхолтой нь, дахин амилахыг гурван талаас илэрхийлдэг гурван янзын грек үг бий.

Энэ гурван үг хүний бие махбод, ухамсарт сэтгэл ба амин сүнс бүгд дахин амилахыг харуулна. Олон орчуулганд эдгээрийг сайн ялгаагүй байдаг. Хүний махбод, амин сүнс ба үүнээс ундрах сэтгэл оюун хоорондоо нягт холбоотой учраас энэ гурван үгний аль аль нь нөгөө хоёр ухагдахуунаа давхар оруулж байгаа нь үнэн.

Энэ гурван үг өмнө нь олж харсан хүний бүтцийг батладаг. Тийм учраас гурвууланг нь агуулдаг 1 Коринт 15:20-22-г үгчлэн орчуулж өгье.

1. “Христ үхэгсдийн дундаас **сэрээгдсэн** [ἐγείρω, эгэйруу; АБ: “амилуулагдсан”] бөгөөд нойрсогсдын анхны үр жимс юм...” (Коринт 15:20)

Үхлээр “нойрссон” **сэтгэл** Их Эзэнээр “сэрээгдэх”-эд тэрхүү сэтгэл ухаан сэхээ орж, дахин юм бодож, сэтгэж, мэдрэх болно.

2. “Үхэл нэг хүнээр [=Адамаар] ирсэн тул үхэгсдийн **босолт** [ἀνάστασις, анастасис; АБ: амилалт] мөн нэг хүнээр иржээ.” (Коринт 15:21)

Булшинд хэвтсэн **бие махбод** шинээр бүтээгдэн сэрэхээр амилсан хүн “босож ирэх” болно.

3. “Адам дотор бүгд үхдэгчлэн Христ дотор бүгд **амьд болгогдоно** [ζωοποιέω, зуопойэуу].” (Коринт 15:22)

“Амьд болгогч нь Сүнс” учраас энэ үг **амин сүнсэнд** шууд хамаатай (Иохан 6:63).



Лазар үхлээс амилуулагдсан (Иохан 12:1, ἐγείρω, сэрээгдсэн) боловч “амьд болгогдоогүй” учраас хожим дахин үхсэн. Харин “амьд болгогдсон” хүн хэзээ ч дахин үхэхгүйгээр амьд болно (1 Тимот 6:13).

Хамгаас түүрүүнд “амьд болгогдсон” “Христ үхэгсдээс амилуулагдсан [грек: сэрээгдсэн] тул дахиж хэзээ ч үхэхгүйг бид мэднэ. Үхэл цаашид Түүнийг захирахгүй.” (1 Коринт 15:23; Ром 6:9).

Грекчүүд хүний сэтгэлийг хойд дүрийн төгсгөлгүй хүрдээр явж шинэ биед шилждэг гэдэгт итгэдэг байсан. Тэдэнд дахин амилалтын тухай сургаал мунхаг санагдсан (Үйлс 17:32). Тиймд “Үхэгсэд яаж амилуулагдах вэ? Тэд ямархуу биетэй ирэх вэ?” гэж асуудаг байсан. Өнөөдөр ч тэгэж асуудаг хүмүүс бий. Энэ асуултанд Паул: “Тэнэг минь ээ, тарьдаг чинь үхэхгүй аваас амилахгүй... Тарьдаг чинь, ирэх ёстой бие бус, харин нүцгэн үр юм... Бурхан Өөрийн хүссэнчлэн түүнд бие өгдөг...” гэж хариулсан (1 Коринт 15:35-38).

Бид дахин амилахдаа өнөөгийн биетэй яг адилхан биеэр босож ирэхгүй нь Паулын үгнээс тодорхой.

Тэрээр дахин амилалтыг соёлж буй үрнээс шинэ ургамал газраас ургахтай зүйрлэсэн. Үрийн амь үхэх явцаар цоо шинэ хэлбэрт шилждэг. Одоогийн бие маань үзэмж муутай, өчүүхэн үр мэт хөрсөнд “таригдана”, харин Мөнхийн Эзэнээс шинээр өгөгдөх амь маань анхилуун цэцэг юмуу сүрлэг мод шиг гайхамшигтай сайхан шинэ биед орших





болно. Шинэ бие маань Бүтээгч Эзэний Шинэ бүтээлд хамаарна.

Амьтан болгон өөрийнхөө амьдрах орчинд таарсан махбодтой (39-р иш). Шувууд тэнгэрт нисэж чаддаг махбодтой байхад загас усны амьдралд зохицсон байдаг. Хүний махбод хөрст дэлхийн гадаргуун дээр амьдрахад зориулсан учраас “газрын бие” гэдэг (40-р иш). Үүгээр ч барахгүй, тэнгэрийн дээр амьдрахаар бүтээгдсэн янз бүрийн “бие” байдгийг Паул дурддаг (41-р иш). Тэнгэрлэг бие лав галын дөлөнд шатахгүй бөгөөд ямар ч асуудалгүйгээр тэнгэр өөд хөөрөх чадвартай (Шүүгчид 13:19-20-г үзнэ үү).



Тэгээд Паул Христийн Биеийнхэнд зориулсан том нууцыг илчилдэг! Үүнд: Бид дахин амилахдаа шууд “өөрчлөгдөж” Есүсийн “дүрийг өмсөж”, өөрөөр хэлбэл Түүн шиг яруу алдартай тэнгэрлэг биетэй болно (49-51-р иш, Филиппой 3:20-21).

“Мах ба цус”-аар бүрдсэн биетэн “Бурханы хаанчлалыг өвлөж чадахгүй” учраас тэр (50-р иш).

Уушиг, цус бүхий махбод агаар мандлаас дээш буй тэнгэрт амьдрахын аргагүй. Хүчилтөрөгчөөр дутагдахаар удалгүй сэхээгүй болох биетэн тэнгэрт оршиж чадахгүй.

Харин тэнгэрлэг биетэн шорооны бүтээгдэхүүнээр ч



тэжээгдэхгүй, агаарын хүчил төрөгчөөр ч амьсгалах шаардлагагүй. Амьтан бүрийг амьдрах орчинд нь тааруулсан Бүтээгч Эзэн тэнгэрт амьдрахад дуудсан хүний биеийг тэр орчинд тааруулж чадах нь мэдээж.

“Үхэгсдийн амилалт нь тийм байна...

муудах байдал дотор таригдаж,

үл муудах байдал дотор

амилуулагдана...

үл хүндлэл дотор таригдаж,

цог жавхлан дотор

амилуулагдана...

мөхөс байдал дотор таригдаж,

хүч дотор амилуулагдана...”

(1 Коринт 15:42-43)



Одоогийн бие маань хүч муутай, сүр жавхлан багатай, ичих зүйл ихтэй бөгөөд улам их муудан доройтдог.

Зүйрлэвээс, одоогийн бие маань салхинд хийсэх, аадар бороонд норох майхан шиг. Харин үхэшгүй бие маань бат бөх сайхан барилга мэт байх болно.

Хэврэг “майхан гэртээ” суухдаа бид (газарзүйн хувьд)

Их Эзэнээс хол, хэцүү амьдралтай. Их Эзэний бидэнд бэлдэн өгч буй нөгөө “сайхан барилга”-д орж суухыг бид хүсэн хүлээдэг (2 Коринт 5:1-9).

Учир нь “бидний иргэний харьяалал нь тэнгэрт байгаа бөгөөд тэндээс бид Аврагч Эзэн Есүс Христийг хүлээж байна.” Их Эзэн Өөрөө “бидний дорд биеийг Өөрийнхөө цог жавхлант биетэй адил болгон өөрчлөнө” (Филиппой 3:20-21).



Үүнээс харахад Есүс Христийн дахин амилсан бие нь бид бүхний дахин амилалтын биеийн загвар юм. Дахин амилалтын бие маань Түүнийх шиг төгөлдөр хүчтэй, цог жавхлангаар туяаран, хэзээ ч муудашгүй бас үхэшгүй байх болно. Амь маань нарны эрчим хүчээр идэвхжүүлсэн хөрс, агаараар биш, харин шууд Бүтээгчээс урсан ирэх болно.

Иймд шинэ бие маань “сэтгэлэг” биш, “сүнслэг” байх болно (1 Коринт 15:44). “Сүнслэг бие” хийсвэр “сүнс биш” харин Есүсийнх шиг барьцтай, юм идэж ууж чадах болно (Лук 24:36-43; Иохан 20:27). Харин “сүнслэг бие” сэтгэлийн шаардлагаар биш, Мөнхийн Эзэнтэй нэгдсэн амин сүнсээрээ удирдуулах болно. Амин сүнс маань одоогоор харанхуйд сүүмэлзэх дэнлүү мэт, харин дахин амилалтанд нар шиг яруу хүчтэй туяарах болно (Үйлс 26:13-г үзнэ үү).

Энэ бол Их Эзэний үг:



“Муудах нь үл муудахыг
өмсөх ёстой бөгөөд
үхдэг нь үхэшгүйг өмсөх
ёстой.

Энэхүү муудах нь
үл муудахыг өмсөж,
үхдэг нь үхэшгүйг өмсөх үед
“ҮХЭЛ ЯЛАЛТАД
ЗАЛГИГДЛАА” гэж
бичигдсэн үг биелнэ.” □



*Дараагийн нийтлэлдээ хүн яагаад үхдэг болсон тухай
авч үзэх болно. Мөн үхлийн хатгууртай танилцана.*

Хэрэглэсэн эх сурвалж

---Ариун Библи (2004; 2013; 2019). Улаанбаатар: Ариун Бичээс
Нийгэмлэг. Энэ судалгаанд АБ гэж товчилсон.

---Vacchiocchi, S. (1998). Immortality or Resurrection?
<https://www.truthaccordingtoscripture.com/documents/death/immortality-or-resurrection/immortality-or-resurrection-ch2.php>

---Стандарт Монгол Орчуулгын апп (2023). Энэ судалгаанд СМО гэж
товчилсон.

---Strong, J. (1890). Strong's exhaustive concordance of the Bible (with
Greek and Hebrew Lexicons). www.blueletterbible.org